



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/661

Есөнбулаг



Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр тогтоол, 2022 оны 12 дугаар сарын 05-ны 78 дугаар тогтоол, 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 71 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 44 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Дэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн тохижилтын зардалд шаардагдах 19,000,000 (арван есөн сая) төгрөгийг "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн батлагдсан зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

